



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЛУУС СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/06

Цагаан-Овоо

Улсын нөөцөөс олгох өвс, тэжээлийг малчдад хуваарилан олгох, Сумын аюулгүй нөөцөөс өвс хямдруулан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.6, Сумын онцгой комиссын 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилт хүндэрсэн багуудад дэмжлэг үзүүлж, хямдралтай үнээр өвс олгох хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Сумын аюулгүй нөөцөөс олгох 760 боодол өвсний үнийг 5000 (таван мянга) төгрөгөөр тооцож нийт 3,800,000 (гурван сая найман зуу) төгрөгийг зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ө.Ариунзаяа)-д үүрэг болгосугай.

3. Улсын нөөцөөс олгож буй өвсний үнийг сумын мал хамгаалах сангийн 100081055403 тоот дансанд шилжүүлэн малчдад хүргэх ажлыг шуурхай зохион байгуулахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Малчдад өвс хуваарилан түгээх, өвсний үнийг дансанд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Э.Энхжаргал), Санхүү албаны дарга (Б.Доржханд) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ӨЛЗИЙХИШИГ

БАТЛАВ
ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА
СУМЫН ЗАСАГ ДАРГА *Б.ӨЛЗИЙХИШИГ*
2023 оны 01 сарын ... *27*

ЛУУС СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН 2023 ОНЫ НЭГДҮГЭЭР ХУРАЛДААНЫ
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2023.01.27-ний өдрийн 12:00 цагаас хуралдана.

№	Хэлэлцэх асуудлын утга	Асуудал оруулах албан тушаалтан	Хуралд асуудал танилцуулах албан тушаалтан	Хурлаас гарах шийдвэр
1	Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хүрээнд өвс хямдралтай олгох болон цаг үеийн нөхцөл байдлын талаар	Сумын онцгой комиссын дарга Б.Өлзийхишиг	Сумын ЗДТГ-ын дарга, сумын шуурхай штабын дарга Б.Ганчимэг	Тэмдэглэл
2	Бусад асуудал			

СУМЫН ОНЦГОЙ КОМИСС

СУМЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023.01.27

Дугаар 01

Луус сум

Сумын онцгой комиссын 1 дүгээр хурлыг 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 10:00 цагт 100 хувийн ирцтэй зохион байгуулав. Хурлыг сумын Засаг дарга бөгөөд онцгой комиссын дарга Б.Өлзийхишиг даргалав.

Хуралдаанд оролцогчид: Б.Өлзийхишиг (Засаг дарга), Б.Ганчимэг (ЗДТГ-ын дарга), Э.Энхжаргал (Засаг даргын орлогч), Б.Доржханд (Санхүү албаны дарга), Х.Адъяасүрэн (1-р багийн Засаг дарга), Б.Шинэтулга (2-р багийн Засаг дарга), П.Тогосмаа (3-р багийн Засаг дарга), Н.Долгоржав (Ерөнхий боловсролын сургууль), М.Үүрийнбаяр (Цэцэрлэгийн эрхлэгч, Э.Сугирсүрэн (Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч), Б.Эрдэнэчимэг (Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- 1.Өвөлжилтийн бэлтгэл ажил хангах ажлын хүрээнд өвс хямдралтай олгох болон цаг үеийн нөхцөл байдлын талаар
- 2.Бусад асуудал

СОНССОН НЬ:

Сумын өвөлжилтийн мэдээлэл, малын гоц халдварт мялзан өвчин цаашид тулгамдаж байгаа асуудал авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Сумын шуурхай штабын дарга Б.Ганчимэг танилцуулав.

Сумын онцгой комиссын дарга Б.Өлзийхишиг: Бог малын мялзан өвчин гарсан 3 өрхийн нөхцөл байдалтай газар дээр нь ажлын хэсгийн хамт танилцаж ажиллалаа анхны сэжигтэй хуц ухна маллаж буй өрхөөс малд шинжилгээ хийлгэх, үргэлжлүүлэн хяналтаа сайжруулах малчидтай гэрээлж пост гаргуулах, хяналтын пост давхар ажиллуулах саналтай байна.

Сумын Засаг даргын орлогч Э.Энхжаргал: Наран багийн малчин өрх, Буянт, Суварга багийн цас ихтэй нутгийн өрхүүд малын хоолгүй байдал хүндэрч байна. Одоогоор малчид өөрсдийн бэлтгэсэн гар тэжээл, нөөц өвс тэжээлээ дуусч, сум аюулгүй нөөцийн өвсийг хуваарийн дагуу малчдад олгоод дуусч байна. Өвс тэжээлийн нөөцөө нэмэгдүүлэх, мөн малчдад хөнгөлттэй үнээр өвс олгох, мялзангийн тухайд даргатай санал нэг байна

Наран багийн Засаг дарга Б.Шинэтулга: Манай сумын айл өрх малын хоолгүй малчид хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна. Тэжээлийн тухайд сумын нөөцөөс зах зээлээс хямд үнээр олгож байгаа болохоор харин өвс ховор үнэтэй байна дэмжлэг үзүүлэх саналтай байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Энэ удаагийн сумын Онцгой комиссын хуралдааны гишүүдийн 100 хувийн саналаар малчдад дэмжлэг үзүүлэх, өвсний нөөц бүрдүүлэх талаар дараах асуудлыг шийдвэрлэв:

1. Улсын нөөцийн хөнгөлттэй үнээр олгож буй 650 боодол өвсийг өвөлжилт хүндрэлтэй байгаа Наран багийн малчин өрхөд 2, мал бүхий өрхөд 2, бусад 2 багийн малчин өрхөд 1 ширхгийг тус тус олгох

2. Улсын нөөцөөс хямдралтай олгож буй тэжээлийг авах эсэх талаар малчин өрхөөс захиалга авах

3. Нийт 378 малчин өрхөд 2 боодол өвс нийт 760 боодол өвсийг нэг бүрийн үнийг 5000 төгрөгөөр хөнгөлөн дэмжлэг үзүүлэх

4. Ургац гурил тэжээлийн үйлдвэрийн хивгийг үргэлжлүүлэн захиалан авах

ДААЛГАСАН НЬ

Шуурхай штаб, Багийн Засаг дарга нар болон Санхүү төрийн сангийн албанд дараах чиглэлийг үүрэг болгов.

- Өвс тэжээлийн нөөц бүрдүүлж ажиллах;
- Улсын онцгой комиссын хөнгөлттэй үнээр олгож буй өвс, сумын аюулгүй нөөцөөс хөнгөлттэй үнээр олгох өвсийг малчин өрх бүрт хүргэх;
- Малын гоц халдварт мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэх, мэдээ мэдээлэл малчдад хүргэж ажиллах, голомтын бүсэд хяналтаа чангатган ажиллах.

ЗАСАГ ДАРГА

ТАНИЛЦСАН:

Б.ӨЛЗИЙХИШИГ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

СУВАРГА БАГИЙН ЗАСАГ ДАРГА

Х.АДЪЯАСҮРЭН

Сумын Засаг даргын 2023 оны 01 сарын 27-ны
А/06 тоот захирамжийн хавсралт






ЗАСГИЙН ГАЗРЫН 461 ДҮГЭЭР ТОГТООЛООР
УЛСЫН НӨӨЦИЙН ТАВИН ХУВЬ ХЯМДРУУЛСАН ӨВС ТЭЖЭЭЛИЙГ
БАГУУДАД ОЛГОХ ХУВААРЬ

№	Багийн нэр	Малчин өрх (тоо)	Өвс (боодол)	Мал бүхий өрх (тоо)	Өвс (боодол)
1	Суварга I-р баг	140	140	36	72
2	Наран II-р баг	116	232	27	54
3	Буянт III-р баг	124	124	8	16
		378	496	71	142
Үлдэгдэл нөөц			12		
НИЙТ				650	

СУМЫН НӨӨЦӨӨС БАГУУДАД ХЯМДРУУЛАН ОЛГОХ ӨВСНИЙ ХУВААРЬ

№	Багийн нэр	Малчин өрх	Өвс боодол
1	Суварга I-р баг	140	280
2	Наран II-р баг	116	232
3	Буянт III-р баг	124	248
	НИЙТ	378	760

ЛУУС ОНЦГОЙ КОМИССЫН 2023 ОНЫ
НЭГДҮГЭЭР ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧДИЙН БҮРТГЭЛ

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг
1	Б.Өлзийхишиг	Засаг дарга	99099129	
2	Э.Энхжаргал	Засаг даргын орлогч	88329003	
3	Б.Ганчимэг	ЗДТГ-ын дарга	88077871	
4	Б.Доржханд	Санхүү албаны дарга	80048882	
5	Х.Адъяасүрэн	1-р багийн Засаг дарга	80028951	
6	Б.Шинэтулга	2-р багийн Засаг дарга	89844988	
7	П.Тогосмаа	3-р багийн Засаг дарга	86024858	
8	Н.Долгоржав	Ерөнхий боловсролын сургууль	99906195	
9	М.Үүрийнбаяр,	Цэцэрлэгийн эрхлэгч	94176575	
10	Э.Сугирсүрэн	Эрүүл мэндийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	85451116	
11	Б.Эрдэнэчимэг	Соёлын төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч	86807070	

СУМЫН ОНЦГОЙ КОМИСС